

Монгол Улсын Визийн ангилал шинэчлэгдлээ.

2021 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Монгол Улсын Засгийн газар “Монгол Улсын виз олгох журам”-ыг (“Виз олгох журам”) баталснаар визийн ангилалд өөрчлөлт орлоо. Энэхүү журам нь 2021 оны 8 дугаар сарын 16-ны өдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлээд байна.

Холбоо барих:

Майкл Ахэрн

Партнер, Татвар, Хуулийн зөвлөх
үйлчилгээ
michael.ahern@pwc.com

Чойжамцын Цэндмаа

Гүйцэтгэх захирал, Татвар, Хуулийн
зөвлөх үйлчилгээ
tsendmaa.choijamts@pwc.com

Марина Тарнавская

Ахлах Менежер
tarnavska.maryna@pwc.com

Батчулууны Амаржаргал

Хуулийн Ахлах Зөвлөх
amarjargal.batchuluun@pwc.com

ПрайсвотэрхаусКүүпэрс Такс ТМЗ ХХК

Сентрал Тауэр, 6 давхар
603 тоот, Улаанбаатар
14200, Монгол улс
Утас : + 976 70009089
Факс : +976 11 322068
www.pwc.com/mn

Нэмэлт Өөрчлөлтөд орсон онцлох зохицуулалтуудаас дурдвал:

- Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулиар Визийн ангиллыг тогтоосон байсныг хүчингүй болгож, Засгийн Газар журам батлан ангилал тогтоохоор зохицуулалт нэмсэн;
- Гадаадын иргэн цахимаар (<https://evisa.mn/main>) виз мэдүүлэх боломжтой төдийгүй гадаадын иргэнийг уригч Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгжүүд цахимаар (<https://eimmigration.mn/>) үйлчилгээ авах боломжтой болсон. Тухайлбал, гадаадын иргэнийг орон байраар хангасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага 48 цагийн дотор бүртгүүлэх бөгөөд бүртгэлийг цахимаар хийж болно;
- Нийтийн эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй халдварт өвчнөөр өвчилсөн, өвчилсөн байж болзошгүй эсхүл Монгол Улсад зорчих, нэвтрэх зорилгоо тодорхойлж чадаагүй, зорчих зорилгодоо нийцээгүй ангиллын визтэй байвал Монгол Улсын хилээр нэвтрэхийг зөвшөөрөхгүй;
- “Гарах-орох” гэсэн зориулалтын виз хасагдаж Монгол Улсад оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэн Монгол Улсын хилээр гараад буцаж ирэх тохиолдолд гарах-орох виз мэдүүлэх шаардлагагүй болсон;
- Монгол Улсад нэвтрэн орох нэг болон хоёр удаагийн виз нь хилээр нэвтрэх хүртэл 90 хоногийн хугацаанд хүчинтэй байсныг 150 хоног байхаар болгож өөрчилсөн;
- Монгол Улсад хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл авах хүсэлтээ гадаадын иргэн хилээр нэвтэрсэн өдрөөс хойш 21 хоногийн дотор гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргах зохицуулалт оруулсан;
- Гадаадын иргэнд хуульд заасан визийн зөвшөөрөлгүйгээр “жуулчин” ангиллын, нэг удаагийн, 30 хүртэлх хоногийн хугацаатай, орох визийг олон улсын хилийн боомт дээр олгох боломжтой болсон;
- Визийн мэдүүлэг хүлээн авах, хүлээн авсан визийн мэдүүлгийг виз олгох байгууллагад дамжуулах чиг үүрэг бүхий визийн төв байгуулах зохицуулалт нэмэгдсэн ба энэхүү төвийг гадаад улсад тусгай зөвшөөрлийн үндсэн дээр байгуулна;
- Гадаадын иргэний бүртгэл, хяналтын сайжруулах үүднээс гадаадын иргэнийг улсын хилээр нэвтрэх үед биеийн давхцахгүй өгөгдлийг авч, хилээр нэвтэрсэн зорчигчийн мэдээллийг нэгдсэн санд бүртгэнэ. Мөн албан болон хувийн хэргээр оршин суугч гадаадын иргэнд түүнийг харьяалах улсын товчлол, төрсөн он, сар, өдөр, хүйс зэрэг өгөгдлийг багтаасан бүртгэлийн дугаарыг олгож, төрийн үйлчилгээ үзүүлэхдээ энэхүү дугаарыг ашиглана.



Энэхүү мэдээллийг PwC Такс ТМЗ ХХК-аас бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, алдаа хийдлээс гарах аливаа хариуцлагыг бид хариуцахгүй болно.



Виз олгох журмаар Монгол Улсын визийг дараах 9 бүлэгт төрөлжүүлэн хуваасан байна. Эдгээр нь:

-  Дипломат, албан зорилгоор;
-  Хөдөлмөр эрхлэх зорилгоор;
-  Цагаачлах зорилгоор;
-  Түр ирэх зорилгоор;
-  Суралцах зорилгоор;
-  Хувийн зорилгоор;
-  Хөрөнгө оруулах зорилгоор;
-  Гэр бүлийн зорилгоор;
-  Шашны зорилгоор.

Дээрх 9 бүлэг нь 64 ангилалтай бөгөөд доорх хүснэгтэд бид Хөрөнгө оруулах болон Хөдөлмөр эрхлэх визийн ангиллыг харуулж байна. Эдгээр нь:

Визийн ангилал					
Хөрөнгө оруулах зорилгоор		Хөдөлмөр эрхлэх зорилгоор			
B-1	Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулагчид	C1	Барилга угсралт, зам, гүүр, бүтээн байгуулалтын салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэнд	C1-1	түүний хамаарал бүхий этгээдэд;
B1-1	Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулагчийн хамаарал бүхий этгээдэд	C2	Шинжлэх ухаан, боловсрол, мэдээллийн технологийн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэнд;	C2-1	түүний хамаарал бүхий этгээдэд;
B2	Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулагчийн төлөөлөгч, гүйцэтгэх удирдлагаар томилогдсон гадаадын иргэнд	C3	Геологи, уул уурхай, газрын тос, эрчим хүчний салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэнд	C3-1	түүний хамаарал бүхий этгээдэд;
B2-1	Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулагчийн төлөөлөгч, гүйцэтгэх удирдлагаар томилогдсон гадаадын иргэний хамаарал бүхий этгээдэд	C4	Санхүү, эдийн засаг, эрх зүйн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэнд	C4-1	түүний хамаарал бүхий этгээдэд;
B3	Гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрын удирдлагаар ажиллах гадаадын иргэнд	C5	Соёл урлаг, спортын салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэнд	C5-1	түүний хамаарал бүхий этгээдэд;
B3-1	Гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрын удирдлагаар ажиллах гадаадын иргэний хамаарал бүхий этгээдэд	C6	Үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэнд	C6-1	түүний хамаарал бүхий этгээдэд;
		C7	Хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэнд	C7-1	түүний хамаарал бүхий этгээдэд;
		C8	Эрүүл мэндийн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэнд	C8-1	түүний хамаарал бүхий этгээдэд;
		C9	Хүмүүнлэгийн салбарт ажиллахаар ирэх гадаадын иргэнд	C9-1	түүний хамаарал бүхий этгээдэд;
		C10	Өрхийн хэрэгцээнд зориулсан асаргаа, үйлчилгээний чиглэлээр ажиллахаар ирэх гадаадын иргэнд		
		C11	Тээврийн салбарт ажиллах болон экспортын ачаа тээвэрлэх гадаадын иргэнд		

Дэлгэрэнгүй мэдээллийг дараах линкнүүдээс авна уу.
<https://www.legalinfo.mn/additional/details/3902?lawid=211>
<https://www.legalinfo.mn/annex/details/12101?lawid=16840>

Энэхүү мэдээлэлтэй холбоотой нэмж тодруулах зүйл байвал бидэнтэй холбогдоно уу.